

УЛС ТӨР

УЛС ТӨР

10 ЖИЛ “АМЫГҮЙ” ЯВСАН “ЭРДЭНЭС МОНГОЛ”-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ УИХ-Д ТАЙЛАГНАХЫГ ШААРДАВ
II нүүрт

ДЭЛХИЙ ТҮҮНИЙГ ҮНЭЛЖ “МАНЛАЙЛАГЧ-ТӨРИЙН ТҮШЭЭ”-ЭЭР ӨРГӨМЖИЛЖЭЭ
IV нүүрт

Улаанбаатар: ӨНӨӨДӨР



ҮЗЭЛ БОДОЛ

МОНГОЛБАНКИНД ХИЙСЭН ШАЛГАЛТ БУЮУ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ӨМНӨХ ШОУ

Дугаарын **60** мөр

Болдод зориулсан нэвтрүүлэг алга, ЯАХ ВЭ

Б.СУМЬЯА

Сарнай охин дөрвөн настай. Тэр монгол хүүхдийн оюун ухаан, сэтгэхүйн онцлогт зориулагдсан бүх нэвтрүүлэг нь монгол хэлээр цацагддаг цорын ганц хүүхдийн телевиз болох “Dreambox”-ын идэвхитэй үзэгч. Түүний ах Болд 16 настай. Одоогоор түүний насны онцлогт тохирсон мэдээ мэдээлэл, нэвтрүүлэг бэлтгэн хүргэдэг телевизийн суваг байхгүй. “Dreambox”-ыг үзэе гэхэд нийт мэдээ мэдээллийнх нь агуулгыг 3-6 насныханд зориулсан хүүхэдлэйн кино, “Бонгын адал явдал”, “Мишээлийн цаг”, “Можухын цаг” гэх мэтчилэн нэвтрүүлгүүд эзэлдэг учир үздэггүй. Бусад телевизийн тухайд хүүхдэд зориулсан тусгай нэвтрүүлэг бараг байхгүйгэй адил.

Үргэлжлэл нь III нүүрт



Үргэлжлэл нь III нүүрт

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

“БОЛОВСРОЛ-2017” НЭЭЛТТЭЙ ХААЛГААР ЗОЧЛОХОД...

Г.ГАНЧИМЭГ

Өнгөрсөн долоо хоногийн сүүлчээр Д.Сүхбаатарын талбайд “Боловсрол-2017” БСШУСЯ-ны нээлттэй хаалганы өдөрлөг болов. Тус өдөрлөгийг Монголын их, дээд сургуулиудын консорциум хамтран зохион байгуулсан нь цаг үеэ олсон ажил байлаа. Жил бүрийн хавар ерөнхий боловсролын дунд сургууль төгсөгчид ямар мэргэжил сонгох вэ, сонгосон мэргэжил нь тухайн хувь хүний онцлогт хэр таарч тохирох вэ гээд амьдралынхаа нэгэн чухал алхмыг яаж хийхээ эргэцүүлэн боддог. Яг энэ үед нь өөрийнхөө төсөөлөл дэх мэргэжлийн онцлог болоод төрөөс боловсролын салбарт баримталж буй бодлоготой танилцах, ганцаарчилсан зөвлөгөө, үйлчилгээ авах боломжийг энэхүү нээлттэй хаалганы өдөрлөг бүрдүүлж өгсөн юм.

Өдөрлөгт төрийн болон хувийн хэвшлийн 40 орчим их, дээд сургууль оролцож, сургалтын үйл ажиллагаагаа иргэд, олон нийтэд нээлттэй сурталчлан танилцуулж, зарим нэг тулгамдсан асуудал дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэв.

Энэ жил улсын хэмжээнд 37.5 мянган хүүхэд ерөнхий боловсролын 12 дугаар анги төгсч байгаа. Тэд бүгдээрээ л дээд сургуульд элсэн орж, хүсэл мөрөөдлийнхөө эзэн нь болж, сонирхсон мэргэжлээ эзэмшихийг зорьж буй билээ. Харин хүсэл мөрөөдөлдөө хөтөлөгдөн сонгосон мэргэжил, төгссөн сургууль тэр болгон зах зээлийн эрэлттэй тохирч байна уу гэвэл үгүй. Тэгвэл ойрын үед хамгийн их эрэлттэй байх мэргэжлийн тухайд БСШУС-ын сайд Ж.Батсуурь “Олон улсын байгууллага болон манай яамнаас жил бүр эрэлт ихтэй мэргэжлийн судалгааг гаргадаг.

Үргэлжлэл нь VII нүүрт

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид үнэмлэхээ авлаа

Н.БАТЗАЯА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд УИХ-ын парламентад суудалтай гурван намын нэр дэвшигчид өрсөлдөж буй. Тодруулбал, МАН-аас М.Энхболд, АН-аас Х.Баттулга, МАХН-аас С.Ганбаатар нар нэр дэвшиж байгаа билээ. Тэгвэл Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдэд өнгөрсөн бямба гарагт СЕХ-оос нэр дэвшигчийн үнэмлэхийг нь гардууллаа. Энэ үеэр СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн “Монгол Улсын Сонгуулийн тухай болон холбогдох бусад хууль, тогтоомжийг дээдэлж оролцох,



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

сурталчилгааны хугацаанд хуулиар хориглосон аливаа үйлдэл, үйл ажиллагаа гаргахгүй байх, сонгуульд оролцсон

зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд гаргаж ирүүлэх”-ийг зөвлөлөө.

Үргэлжлэл нь III нүүрт

Нийтлэл · Яри

MMINFO АПП

Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

TATAХ
PLAY STORE

TATAХ
APP STORE

НИЙГЭМ МАРГААШН ЭХЭЛНЭ
2 цагийн өмнө

САНАЛ БОЛГОХ ШИНЭ МЭДЭЭ

НИЙГЭМ МАРГААШНААС БҮСЭЭ ЧАНГАЛАХ САР ЭХЭЛНЭ
2 цагийн өмнө

АСЕМ-ын “Ази-Европын Хүнсний аюулгүй байдал”-ын

БҮХ СЭДЭВ ▾

Шилдэг · Архив

САНАЛ БОЛГОХ

ХААН банк	Хугалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2400.00	2419.00	ФУНТ	3066.00
ЕВРО	2666.00	2731.00	РУБЛЬ	41.50
ИЕН	21.44	21.70	ЮАНЬ	348.50

ҮЗЭЛ БОДОЛ

МОНГОЛБАНКИНД ХИЙСЭН ШАЛГАЛТ БУЮУ ШОУ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ӨМНӨХ

Дугаарын **60** мөр

Болдод зориулсан
нэвтрүүлэг алга,
ЯАХ ВЭ

Н.ПУНЦАГБОЛД

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос ажлын хэсэг гаргаж, Монголбанкинд шалгалт хийсэн билээ. Гэхдээ одоо хэрхэн ажиллаж байгааг нь шалгасан юм биш. Өмнөх дөрвөн жилд хэрхэн ажилласан бэ гэдгийг шалгасан хэрэг. Энэхүү шалгалтыг хийсэн Ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан ажилласан. Мөн ажлын хэсэгт нь хэд хэдэн гишүүн багтсан. Улмаар шалгалтын дүн гарч, энэ сарын 25-нд танилцуулсан. Эдийн засгийн байнгын хорооны хурлын үеэр танилцуулсан гэдгийг энд тодотгох нь зөв байх. Шалгалт хийсэн ажлын хэсгийнхний тогтоосноор өнгөрсөн дөрвөн жилд тун ч их алдагдалтай ажилласан юм байх. Ажлын хэсгийн ахлагч Т.Аюурсайхан хэвлэлд өгсөн ярилцлагадаа “Монголбанкны алдагдал 2012 оноос эхэлж хуримтлагдсан байдаг. Жшээ нь, 2011 онд 179 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байсан бол 2012 оноос 280 тэрбумын алдагдалтай болсон юм билээ. Ингэж явсаар 2016 онд жилийн 1.6 их наяд болж нийт гурван их наяд төгрөгийн алдагдалтай болсон байна. Энэхүү алдагдлыг хуулиар төсвөөс хаадаг. Ингэхдээ Засгийн газар үнэт цаас гаргадаг. Татвар төлөгчдийн халааснаас гарна гэсэн үг. Ийм л нөхцөл байдал үүссэн. Ажлын хэсэг үүнийг нягтлаад юунаас болов гээд шалгаад үзэхээр “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-тэй холбоотойг тогтоосон. Монголбанкны үйл ажиллагааг Төв банкны тухай хуулиар маш тодорхой заагаад өгчихсөн байдаг. Гэтэл хуульд заагаагүй арга хэмжээг хэрэгжүүлсэн, түүнээс давсан үйл ажиллагаа явуулсан, зөрчсөн, бодлогын уламжлалт бус арга хэмжээг явуулсан байгаа юм. Үүний нэг нь “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”. Хөтөлбөрийн хүрээнд 4.8 их наяд төгрөгийг зах зээлд маш бага хүүтэйгээр аж ахуйн нэгжүүдэд олгосон байдаг.



Үүнээс 369 тэрбум төгрөгийг зориулалтын бусаар зарцуулсныг тогтоосон” хэмээн хэлжээ. Дахиад жаахан тодруулчихъя. 4.8 их наядын 3.7-г нь ипотекийн зээл рүү оруулсан. Үлдсэн мөнгийг нь буюу 1.16 их наяд төгрөгийг өргөн хэрэглээний барааны үнэ тогтворжуулахад зарцуулсан гэсэн шалгалтын дүн гарч. Тэр дунд шатахууны үнийг барихад ч бас зарцуулсан байгаа юм. Мөн “Сайн” нэртэй хөтөлбөрүүдэд тодорхой хэмжээнд зарцуулсан аж. Өнгөрсөн хугацаанд 70, 80 мянган айл өрхийг орон сууцанд оруулсан “Ипотекийн зээл”-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж 3.7 их наяд төгрөг зарцуулж. Шалгалт хийсэн хүмүүс уламжлалт бус арга гээд байгаа юм. Тэр нь юу ч гэсэн үг юм, бүү мэд. 2017 оны дөрөвдүгээр сарын сууц авсан зээлдэгчдийн тоо 90850 хүрсэн. Эдгээр иргэдийг бараг 80 хувьд нь өнгөрсөн дөрвөн жил зээл олгосон гэхэд болно. 70-80 мянган айл өрх тохилог сууцанд орчихлоо. Одоо ипотекийн зээлийн эх үүсвэр болсон эргэн

төлөлтийн мөнгө дээр дурьдсан 3.7 их наядас улбаатай. МАН-ын эрх баригчид өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн суурин дээр Ипотекийн зээлийг үлгэн салган явуулсан нэр зүүж байгаа шүү дээ. Гэтэл одоо үүнийг буруу байсан мэтээр дайрч байгаа нь нэг талаар инээдтэй. Тэгээд ч энэ мөнгийг Монголбанкнаас шууд зээл гээд өгчихөөгүй. Арилжааны банкуудаар дамжуулж байгаа. Хамгийн авууштай нь тэр үеийн удирдлагууд маш том зориг гаргаж, иргэддээ орон сууцны хөнгөлөгттэй зээл өгсөн. Энэ юуны буруу гэж. Сайдын багц нэмж, татвараар дарамталснаас л дээр биш үү. Нөгөө талаар Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг тодорхой хэмжээнд хэрэгжүүлэх л ёстой байсан. Шатахууны үнэ тэнгэрт хадвал дагаад өргөн хэрэглээний барааны үнэ өснө. Тэгвэл эдийн засаг яах билээ. Тэгээд ч шатахуун импортлогчид бүтээгээр л МАН-ын угшилтай хөрөнгө шүү дээ. Нөгөө талаар олон компанид зээл олгож, эдийн засгийг тэтгэж байсныг огт буруу гэж дайрах нь нэг талдаа

бас өрөөсгөл. Яахав, тэр зээлийг зориулалтын бусаар ашигласан гэдэг дээр жаахан асуудал үүсгэж болох юм. Ерөнхийдөө хэдэн төгрөг зориглон гаргаж, орон сууцны бага хүүтэй зээл өгч, иргэдээ дэмжсэнийг л одоогийн эрх баригчид буруутгах гээд байна уу. Нөгөө талдаа Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө хар пи ар болгон ашиглахыг ч оролдож байж болох. Эдийн засгийн байнгын хорооны хурлын үеэр шалгалтын дүн танилцуулахдаа зарим гишүүд “Хохирол учирсан, Монголбанкны өмнөх Ерөнхийлөгч Н.Золжаргалаар төлүүлэх ёстой” гэх мэт явцуу саналыг хэлж байсан. 4.7 их наядын зөрчил гээд л байгаа. Гэтэл тэр мөнгө нь алга болчихоогүй байгаа шүү дээ. Тэр дундаа ипотекийн зээлд олгосон мөнгө алга болох нь битгий хэл өсч байгаа. Одоо нийт ипотекийн зээлийн мөнгө 4.11 тэрбум төгрөг болчихсон. Чанаргүй зээл нь ердөө 1.8 хувьтай байгаа. Маш бага. Ерөөс эргэн төлөлт маш сайтай гэсэн үг. Хэрвээ

тэгтлээ хохиролтой л байгаа юм бол ипотекийн зээлийн эргэн төлөлтөөс орж ирж буй мөнгийг төсөврүү татаад, аваач дээ. Тэгээд энэ хөтөлбөрөө шууд зогсоогүй юу. Нөгөө талаар 45 компанийн нэр зээлтэй холбогдоод байгаа. Удахгүй нэр нь тодорхой болох юм гэсэн. Тэр үед хэн тэр зээлийг авсан нь тодорхой болох байлгүй. Дээрээс нь Т.Аюурсайхан гишүүн “Тухайн үед Үйлдвэр, хөдөө ахуйн сайдаар ажиллаж байсан Х.Баттулга, Барилга, хот байгуулалтын сайдаар ажиллаж байсан Ц.Баярсайхан, Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал нарын шийдвэртэй холбоотой зөрчлүүд бий. Эдгээр хүнийг хууль хяналтын байгууллагад ийм үндэслэл, баримтын дагуу шалгуула гэдэг санал гаргачихсан байгаа” хэмээн ярьсан байсан. Энэ бол Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшиж байгаа Х.Баттулга руу чиглэсэн хар пи ар гэж харагдаад байна. Өөр харлуулах юм олдохгүй болохоор Монголбанкинд шалгалт хийсэн нэр зүүж, дайрах гээд байна уу гэсэн хар төрөөд байгаа юм.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИД ҮНЭМЛЭХЭЭ АВЛАА



Гэрээ зургийн Г.АРГУУЖИН

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Нэр дэвшигчийн үнэмлэхээ хамгийн эхэнд МАН-аас нэр дэвшигч М.Энхболд гардан авсан юм. Түүнийг дагаж МАН-ын гишүүд, дэмжигчид хүрэлцэн ирсэн байлаа. Харин дараа нь АН-аас нэр дэвшигч Х.Баттулга нэр дэвшигчийн үнэмлэхээ гардан авсан бөгөөд АН болон ИЗНН-ын гишүүд дэмжихээр ирсэн юм. Энэ үеэр Монгол Улсын 17 дахь Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн нэр дэвшигч Х.Баттулгад хадаг, мөнгөн аяганы хамт гардуулан амжилт хүссэн юм. Түүний дараа С.Ганбаатар нэр дэвшигчийн үнэмлэхээ СЕХ-ны дарга Ч.Содномцэрэнгээс хүлээн авлаа. Энэ үеэр Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид ийн ярилаа.

Х.Баттулга: Монголчууд ялах болно

/АН-аас нэр дэвшигч/

“Өнөөдөр үнэмлэхээ хүлээж авлаа. “Монгол Улсын 30 хүрэхгүй гэр бүлийн төлөө юу. Гурван сая иргэдийн төлөө юу” гэдэг шийдвэрийг гаргахад сар хүрэхгүй хугацаа үлдсэн байна. Хүч тэнцвэргүй тулаан болно. Тэдэнд эрх мэдэл, алт мөнгө бүгд байгаа. Бидэнд эгэл ардууд, монголчууд, ардчиллагчид байна. Монголчууд ялах болно

С.Ганбаатар: Бидэнд Монгол орноо аврах төлөвлөгөө байгаа

/МАХН-аас нэр дэвшигч/

“Өнөөдрийг хүртэл хол замыг, удаан туулаа. Олон доромжлол дундуур алхаж ирлээ. Үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцдэг

гэжүг бий. Үнэн гүйцдэг юм байна. Өнөөдөр жирийн ард иргэд улс орныхоо тусгаар тогтнолын төлөө санаа зовж байна. Монгол Улсыг эдийн засгийн хүндрэлд оруулсан намуудаас нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаагаа ард түмнээсээ уучлалт гуйж эхлэх ёстой. Монголын ард түмнийг лиценз, газрын наймаа, тендерийн луйврууд ядрааж байна. Бидэнд Монгол орноо аврах төлөвлөгөө байгаа. Монгол Улсаа цэгцтэй хөгжүүлэх Үндсэн хуулийн төсөл байгаа. Илүү мөнгө хөрөнгөтэй нь ялдагаас өөр сонгууль хийх хэрэгтэй. Илүү төлөвлөгөөтэй, сэтгэл зүрхтэй, үзэл баримтлалтай нь ялах ёстой. Монгол Улсын Ерөнхийлөгчийг ард түмэн дундаас сонгодог. МАХН жирийн ард түмний төлөөлөл Монгол Улсын тавь дахь Ерөнхийлөгч болох боломжийг олголоо. Намын дарга Н.Энхбаярт талархаж байна. Зүйл хүнийг хайрх, хүтэсэн олон зүйлийг би үргэлжлүүлнэ. Монголын ард түмэн ялж, Монгол босно.

М.Энхболд: Энэ удаагийн сонгууль бол Монгол орны хямарсан байдалд цэг тавих сонголт

/МАН-аас нэр дэвшигч/

“МАН надад их итгэл найдвар, даалгавар, харууллагатай үүрэг хүлээлгэсэн. Би энэ сонгуульд хуулийн дагуу, шударга өрсөлдөж, ялалт байгуулж чадна гэдэгт итгэлтэй байна. Энэ бол зөвхөн Ерөнхийлөгчийг сонгох сонгууль биш юм. Энэ удаагийн сонгууль бол Монгол орны уруудсан, доройтсон, хагарсан, хямарсан байдалд цэг тавих сонголт юм. Үүний зэрэгцээгээр Монголын ард түмний эв нэгдэл, Монгол Улсын хөгжил цэцэглэлтийн шинэ замыг сонгох сонгууль болох болно. Энэ шинэ зам дээр гарахын тулд унах хүлээ, хүрэх зам, зорилгоо тодорхойлох ёстой. Би сайн хүлгийг үндэсний эв нэгдэл гэж харж байна.

Монголчууд эвтэй байхдаа эх орноо хөгжүүлж, аж амьдралаа дээшлүүлж, тусгаар тогтнолоо улам бүр баталгаажуулж ирсэн түүхтэй. Бид эе эвдэрч явсан үедээ эрч хүч, ухаан дутаж байсан гашуун сургамжтай. Үүнийг бид ямагт санаж байх ёстой. Өнгөрсөн он жилүүдийн алдаатай бодлого, хайхрамжгүй хандлагын улмаас улс орны эдийн засаг ямар байдалд орсон бэ гэдгийг бид сайн мэдэж байгаа. Монголын ард түмэн 10 сарын өмнө бидэнд их итгэл хүлээлгэсэн. Энэ итгэл найдварын ард байгаа том даалгаврыг бүрэн биелүүлэхийн төлөө би өрсөлдөж байна. Бид нэгдмэл байр суурьтай, нэг улс болохын төлөө ажиллах болно. Миний зүгээс МАХН болон АН-аас нэр дэвшиж буй хоёр эрхэмд хандаж, сонгуульд гүтгэлзгүүгээр, бодлого, мөрийн хөтөлбөрөөрөө өрсөлдөхийг уриалсан захидал бичсэн. Энэхүү захидалыг нэр дэвшигчид маань хүндэтгэн хүлээж авна гэдэгт итгэлтэй байна.

ОНЦЛОХ ХУУДАС

Сенсаацийн эргэн тойронг

ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН БҮС ОРОН СУУЦНЫ БАРИЛГАД ЭЗЛҮҮЛЭХ НЬ

Өнгөрсөн долоо хоногт олон нийтийн анхаарлыг хамгийн ихээр татсан асуудал Соёмботой уулын бэлийг ухсан хэрэг байлаа. Богд Хан уул уг нь дархан цаазат газар. Гэвч Зайсангийн ам аль хэдийнэ орон сууцны барилгын “дайралт”-д өртөж, нэгэнт эзлүүлчихээд байгаа. Тэнд уулыг нурааж, усыг эргүүлж, орон сууц барьсаар л. Тэгвэл одоо Зайсангийн амнаас халиад бусад газар руу орж эхэлсэн нь Соёмботой уулыг ухсанаас харагдаж байна. Мөн “Энигма” гэх компани дархан цаазат бүсэд газар эзэмшиж, дураараа авирласан асуудал ч өнгөрсөн долоо хоногийн гол шуугиан байлаа. Тиймээс “Монголын мэдээ” сонин энэ удаагийн “Онцлох хуудас”-аараа энэ асуудлыг хөндөж байгаа юм.

Ч.БАТСАНСАР: “ЭНИГМА”-Д УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫГ ӨМЧЛӨХ, ЭЗЭМШИХ ЭРХ БАЙХГҮЙ

/Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга/

“Зайсангийн 11 дүгээр хорооны эцэст барьж байгаа МҮИС, “Универсал” политехникийн коллежтэй холбоотой 3 га газрын асуудлаар оюутнууд жагсч байна. Нэг зүйлийг тодотгон хэлэхэд, улсын тусгай хамгаалалттай газрыг эзэмшүүлж, өмчлүүлдэггүй. Ийм эрх зүйн зохицуулалт байхгүй. Тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалын зориулалтаар таван жилээр ашиглах эрхтэйгээр газар олгодог. Тэрнээс биш их дээд сургууль барьж болохгүй. Ийм эрх зүйн үндэслэл ч байхгүй. Тус газарт, газар ашиглах эрх авсан “Энигма” компани “Эко” буюу байгаль орчинд ээлтэй сургууль барих гэж байтал үйл ажиллагааг нь зогсоолоо гэж эсэргүүцээд байгаа юм. Бодит байдал дээр баталсан төлөвлөгөө, төсөл юу ч байхгүй. “Гэтэл өнөөдөр Улаанбаатар хотын иргэд Богд уул руу явган аялалд гарахаар очиход машин тавих газаргүй байна. Богд уулын бүсээс “Энигма” компанид 2003 онд 40.1 га газар олгосон байдаг. Энэхүү нийтийн эзэмшлийн талбайгаас гурван га газрыг нь чөлөөлж, явган хүний автозам, дугуйн зам, нийтийн бие газар, аялал жуулчлалын дагуух зам, хогийн сав зэргийг барихаар НИТХ-аар гурван тэрбум төгрөг 2016 оны төсөвт батлуулсан. Энэ газар бол нийтийн эзэмшлийн зогсоол болно. Улаанбаатар хотын иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх газрыг л төрөөс байгуулах гээд байгаа юм. Нийтийн эзэмшлийн талбайг төр ашиглах эрхтэй шүү дээ. Энэ хуулийн дагуу л бид асуудалд хандаж байна.

БОГД УУЛЫН ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫГ “ЭНИГМА” КОМПАНИ УЛСАД ЧӨЛӨӨЛЖ ӨГӨХ ҮҮРЭГТЭЙ

2017.05.23: Байгаль орчин аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Ч.Гал дархан цаазат газарт газар эзэмшсэн гэх “Энигма” компанийн асуудлаар ярьсан байна. Тэрбээр “Газрын судалгаа хийж үзэхэд, Зайсан - Дугуй цагаан - Баруун ширээт гэсэн маршрутад “Энигма” компанийн газар болох 41 га газрыг хашчихсан байсан. Аялалын бүс, чиглэлийн гол газрын авто зогсоолын асуудлыг шийд гэсэн Засгийн газрын үүрэг даалгаврын дагуу Нийслэлийн газрын алба, Ерөнхий төлөвлөгөөний газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдал, цагдаа гээд бүх чиглэлээр хамтарч, шалгалт хийсэн. Шалгалтаар энэ компани тэнцэхээргүй дүгнэлтүүд гарсан. Тухайлбал 481 сая төгрөгийн Улсын төсөвт төлөөгүй, өртэй гэх мэтчилэн тодорхой судалгаанд дээр үндэслэн бид 41 га газраас 3 га газрыг чөлөөлсөн. Чөлөөлсөн уг 3 га газар дээр их сургуулийн үйл ажиллагаа явуулах зүйл огт байхгүй. Сургууль барихаар батлагдсан ямар ч зураг төсөл байхгүй. Үнэн хэрэгтээ тэнд жуулчны бааз, гэр, ресторан, зугаа цэнгээний газрууд ажиллуулж байсан. Тэгсэн хэрнээ “Энигма” компани нь газраа хоёр, гурав хувааж, их сургууль барина гэх нэрийн дор газрын төлбөрөөс зугтаасаар ирсэн юм билээ. Газрын төлбөрийн тухай хууль дээр бүх шатны боловсролын байгууллагыг газрын төлбөрөөс чөлөөлнө гэсэн байдаг. Энэ мэтчилэн хуулийн цоорхойг ашиглах байдлаар үйл ажиллагаагаа явуулж байсан” хэмээн ярьсан.

СОЁМБОТОЙ УУЛЫГ УХАЖ ЭХЭЛЛЭЭ

2017.05.23: Нэг л өглөө фэйсбүүк хуудсаар Соёмботой уулыг хормойноос сэмлэн ухаж буй зураг тарсан. Энэ талаар мэдээллийн сайтууд бүгд мэдээлсэн билээ. Тодруулбал, “Нийслэл хотын өмнө зүгт, Зайсанд байрлах Соёмботой уулыг өнөө өглөөнөөс ухаад эхэллээ гэх шуум олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр зураг хөрөгтэйгөө цацагдсаар байна. Үнэхээр ч тэнд нэг байшингийн суурь цутгах зориулалттай бололтой газар ухаад эхэлжээ. Уулын бэлийг өгсүүлээд ухаж эхэлсэн байдлаас харахад, бодвол албан ёсны баталгаатай зөвшөөрөлтэй эрхмүүд бололтой. Харин энэ ууланд тэдэнд газар олгосон эрх мэдэлтнүүд бүр их сонирхол татахаар. Нийслэлийн ойролцоох газрууд бүгд дууссан болохоор ийнхүү уул хад руугаа халдаж эхэлж буй аж” хэмээн бичиж байлаа.

СОЁМБОТОЙ УУЛАНД ОЛГОСОН ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙГ ЦУЦАЛЛАА

2017.05.24: Богдхан уулын дархан цаазат газар Соёмботой уулыг ухаж эхэлсэн талаар иргэд цахим сүлжээнд нийтэлсэн. Энэ дагуу холбогдох байгууллагууд ажиллаж, “Аялж уул” гэх компанийн үйл ажиллагааг зогсоогоод байсан. Уг асуудлаар өнгөрсөн долоо хоногийн эхээр БОАЖЯ-наас мэдээлэл хийлээ. Мэдээллийн үеэр Н.Батцэрэг сайдаар ажиллаж байх үедээ Соёмботой ууланд таван иргэнд газар өгсөн байсан гэдгийг хэлсэн. Харин эдгээр газрууд нь явсаар компаниудад шилжсэн байна. Тэгвэл Соёмботой ууланд олгосон дээрх газрын зөвшөөрлүүдийг цуцалсан гэдгийг яамнаас мэдээлсэн юм. Улмаар ухаж сэндинчсэн газрыг тухайн компаниар нөхөн сэргээлгэхээр болжээ. Дашрамд дуулгахад тусгай хамгаалалттай газар нутагт тав хүртэлх жилээр ашиглуулахаар газар олгодог байна. Харин сүүлийн жилүүдэд иргэд ашиглахаар зөвшөөрөл авсан ч зориулалтыг нь өөрчлөх болсон байна. Энэ талаар усгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга Ч.Батсансар хэвлэлийн бага хурлын үеэр хэлэхдээ “2001 онд батлагдсан Байгаль орчин аялал жуулчлалын сайдын Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын зориулалтаар газар олгох түр журам байдаг. Тэнд зааснаар Тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын бүсэд таван жил хүртэлх хугацаагаар олгоно гэсэн заалт байдаг. Мэдээж онгон болон хамгаалалтын бүсэд газар олгохгүй. Богд ууланд онгон болон хамгаалалтын бүсэд олгосон газар байхгүй. Манай улс ЮНЕСКО-д элссэн. Бидэнд тусгай хамгаалалттай газар нутагт амьдарч байгаа ард иргэдийнхээ нийгмийн асуудлыг шийддэг ээ гэсэн шаардлагыг тавьдаг. Энэ шугамаар бид аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглахыг дэмжээд явж байна. Харамсалтай зөвшөөрөл авсан хүмүүс нь хуулийн зориулалтаар ашиглахгүй байгаа явдалд асуудал үүсээд байна” гэлээ. Одоогоор тусгай хамгаалалттай газар нутагт буюу Богдхан уулыг тойроод 2000 орчим иргэн ААН-д тусгай зөвшөөрөл олгосон байгаа аж.



Сэтгүүлчийн өнцөг

ГАЗРЫН НАЙМАА ОДОО БОЛТОЛ “АМЬДАРСААР” БАЙНА УУ

Н.БОЛД

Ингэж асуух хэцүү юм. Зарим нэг нь уугаасаа л байгаа шүү дээ гэж харуулах байх. Гэхдээ яг тэр, тийм газрыг зараад, мөнгө олчихсон гээд баталчих баталгаа алга. Тийм болохоор асууж байна. Өнгөрсөн долоо хоногт Соёмботой уулын хормойг “Аялж уул” гэх компани хэв нэг ухаж эхэлсэн. Иргэд фэйсбүүкээр зургийг цацаж, асуудал тавьснаар БОАЖЯ-наас тус компанийн газар эзэмших эрхийг нь цуцаллаа. Улмаар нөхөн сэргээлт хийлгэхээр болсон. Түүнээс гадна Зайсангийн аманд газар эзэмшиж, дураараа дургиж байсан “Энигма” гэх компанитай холбоотой асуудлыг ч яамнаас шийдээд байгаа. Гурван га газрын л асуудал юм билээ. Хууль бусаар үйл ажиллагаа явуулсан учраас газар эзэмших эрхийг нь цуцалсан. Гэтэл энэ компани оюутнуудыг турхирч, жагсаал хүртэл хийлгээд амжсан. Ер нь Монголд төр засаг гэж байна уу.

Зүгээр нэг мөнгөтэй хүн, компани хаа дуртай газраа газар аваад, юу ч хамаагүй хийж байна шүү дээ. Сүүлдээ компанийнхаа харьяа сургуулийн хэдэн оюутныг жагсаагаад л. Яасан том толгойтой, эрх мэдэлтэй байдаг юм. Ер нь бол зарчмын нэг л асуудал байгаа. Дархан цаазтай, улсын тусгай хамгаалалттай газарт газар өмчлүүлэх, эзэмшүүлэхийг хориглодог хуультай. Тэр хуулиа л төрийн томчууд, салбар яамныхан мөрдөж ажиллах ёстой. Гэтэл өнгөрсөн жилүүдэд аялал жуулчлалын гэх нэрийн дор олон компани тусгай хамгаалалттай газар руу “хуруу дүрж”, барилга барьсан. Одоо Зайсан толгой хавийн ам орон сууцны барилгаар

дүүрчихсэн. Нэгэнт барьсан барилгыг нураалтай биш. Уг нь төр ажлаа хийж чаддаг эхлээд барилга барих гээд газар ухаж эхлэх үед нь таслан зогсоох байсан юм. Одоо нэгэнт хүн амьдарч байгаа барилгуудыг яалтай. Иргэдээ Богд уулын бусад амуудыг энэ мэтээр алдчихмааргүй байна. Соёмботой ууланд газар эзэмших эрхийг Н.Батцэрэг гэдэг нөхөр Байгаль орчны сайдаар ажиллаж байхдаа л өгсөн гээд байгаа. Тэр хүн бас л аялал жуулчлалын гэсэн нэрийдлээр газар өгсөн байх. Ер нь энэ аялал жуулчлалын гэх нэрийдлээр газар өгч, наймаа хийдэг жишиг байгаа юм

биш үү. Одоогийн сайд нь тэр жишгээр арай явчихаагүй байх гэж найдаа. Сая гаргасан хэд хэдэн шийдвэрийг харахад арай өөрөөр ажиллаж байна уу гэсэн итгэл төрөөд байна. Тийм болохоор өмнөх сайдын үед ямар газрыг, яаж эзэмшүүлсэн, өгсөн болохыг судалж, шалгаж тогтоох хэрэгтэй юм биш үү. Нэг л өглөө босоход Богд уулыг өөр нэг газраас нь ухаж, төнхөж байх вий дээ. Түүнээс нь өмнө эртхэн шалгаад, цуцлах юм байвал цуцалсан нь дээр. Одоогоор тусгай хамгаалалттай газар нутагт буюу Богдхан уулыг тойроод 2000 орчим иргэн ААН-д тусгай зөвшөөрөл олгосон байгаа гэж БОАЖЯ-наас мэдээлсэн.

Тэд бүгдээрээ аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулаад, сүр болох уу. Ёстой үүн шиг худлаа юм байхгүй шүү, Д.Оюунхорол сайд аа. Тэд бүгдээрээ л Богд уулыг ямар нэг байдлаар ухна. Барилга барина. Тийм болохоор бүгдийг нь цуцлах хэрэгтэй юм биш үү. Өмнө нь тусгай зөвшөөрөл авсан болгон барилга барьчихаад байна. Ямар компани аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа юм. Ёстой харагдахгүй байна. Хоёр амралтын газар маягийн юм байгааг эс тооцвол шүү дээ. Тийм болохоор эртхэн энэ олон зөвшөөрлөө цуцлаад, хуулийнхаа дагуу л үйл ажиллагаа явуулаач дээ.

Пхеньян



НИСЭХ ОНГОЦ ЭСЭРГҮҮЦЭХ СИСТЕМ ТУРШЛАА

Б.ДАВААХҮҮ

БНАСАУ долоо хоног тутамд баллистик пуужингийн туршилт хийж, зэвсэглэлийнхээ технологийг сайжруулсаар байна. Тус улсын нөлөө бүхий албан тушаалтан “BBC” телевизэд өнгөрсөн сард ярилцлага өгөхдөө “Бид долоо хоног, сар, жил тутамд пуужингийн туршилт хийх болно. Хэрвээ АНУ цэргийн ажиллагаа явуулбал, дайн дэгдэнэ” хэмээн мэдэгдэж байсан юм. Тэгвэл энэ дагуу сүүлийн гурван долоо хоногийн

ням гараг бүр Пхеньян Япон тэнгисийн зүг пуужин харваж туршаар байна. Хамгийн сүүлийн зэвсгийн туршилтаат эд өчигдөр хийв. Хойд Солонгосын “КСНА” агентлагийн мэдээлснээр, өчигдөр өглөө үүрээр шинэ загварын агаарын хөлгийг устгах системийн туршилтыг хийж, амжилттай болсон хэмээн мэдээллээ. Мөн туршилтыг тус улсын удирдагч Ким Жон Ун өөрийн биеэр удирдаж, нөхцөл байдалтай нь танилцжээ. Гэхдээ одоогоор яг хэдэн цагийн орчимд, хаана туршсан нь тодорхойгүй байгаа

юм. АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп тус улсыг цөмийн зэвсэг болон баллистик пуужин туршиж буй нь бүс нутагт аюул учруулж байна хэмээн үзэж, хоёр ч цохилтын хүчээ илгээгээд байгаа. Тэгвэл нөхцөл байдал хурцадмал байгаа энэ үед Пхеньян агаарын хөлөг устгах системийг туршсан нь АНУ-ын хүчийг сөрөх зорилготой хэмээн судлаачид онцолж байна. “КСНА” агентлагийн мэдээлж буйгаар пуужингийн туршилт амжилттай болсны дараа Ким Жон Ун “Өнгөрсөн жилийнхээс ч илүү байгаа олж илрүүлэх,

дагах хүчин чадал нь сайжирсан байна. Нарийвчлал нь нэмэгдэж, өнгөрсөн жил гарч байсан алдаа дутагдлыг арилгаж чадлаа. Маш сайн” гэж магтаж, үйлдвэрлэл болон тоноглолын талаар заавар чиглэл өгчээ. Пхеньян өнгөрсөн оны дөрөвдүгээр сард ч гэсэн нисэх онгоц устгах системийг туршиж байжээ. Нөгөөтэйгүүр, Хойд Солонгосын хөгжүүлж буйтай ижил төрлийн тив хоорондын баллистик пуужинг утган устгах туршилтыг одоогийн ашиглаж байгаа пуужингаас хамгаалах системд гүйцэтгэхээр болсноо АНУ-

ын тал өнгөрөгч баасан гарагт мэдэгдэж байсан удаатай. Тэдний мэдэгдсэнээр, маргааш буюу мягмар гарагт АНУ анх удаагаа тив алгасгач баллистик пуужинг устгах туршилтаа хийх юм. Хуурай газарт байрлах “Ground-Based Midcourse Defense” хамгаалах системийг пуужингийн довтолгооны эсрэг ашиглахаар бэлдсэн байдаг ч дээрх төрлийн пуужингийн эсрэг хэзээ ч хэрэглэж үзээгүй аж. Нэгэнт Хойд Солонгос ийм зэвсэг бүтээж байгаа нь тодорхой, хэзээ нэгэн цагт аюул

учруулах төвшинд хүрэх тул бэлтгэлтэй байх ёстой гэж АНУ-ын зэвсэгт хүчнийхэн үзжээ. Номхон далай дээгүүр АНУ-ын эргийг чиглэн ирэх байг Калифорний Ванденбергийн Агаарын Баазад байрлах хамгаалалтын систем устгахаар төлөвлөгдсөн байна. Уг бааз нь Калифорни, Аляска мужуудад байрлах нийт 36 агаарын баазын нэг юм. Уг хамгаалалтын систем нь 1999 оноос хойш явуулсан 17 туршилтын эсийг нь амжилттай гүйцэтгэсэн үзүүлэлттэй юм. Хамгийн сүүлд ийм туршилтыг 2014 онд явуулж байжээ.



Д.ТРАМП ИРЭХ ДОЛОО ХОНОГТ ШИЙДВЭРЭЭ ГАРГАНА

Уур амьсгалын өөрчлөлтийн талаархи Парисын хэлэлцээрээс АНУ-ыг гаргах эсэхийг тун удахгүй шийдвэрлэхээ тус улсын Ерөнхийлөгч Доналд Трамп мэдэгдлээ. Тэрбээр твиттер хуудастаа “Уур амьсгалын өөрчлөлтийн хэлэлцээртэй холбоотой асуудлаарх эцсийн шийдвэрийг ирэх долоо хоногт гаргана” хэмээн жиргэжээ. Уур амьсгалын өөрчлөлтийг “зохиомол сэдэв” гэж үздэг тэрбээр өнгөрсөн онд болсон ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр “АНУ-ыг Парисын хэлэлцээрээс гаргана” гэж амлаж байсан билээ. Хүлэмжийн хийн ялгаралтыг багасгах зорилго бүхий Парисын хэлэлцээрээс гарахгүй байхыг “Их долоо” бүлгийн Дээд хэмжээний уулзалтын үеэр түүнд тус бүлгийн гишүүн бусад зургаан улсын удирдагчид

уриалсан юм. Хэрвээ АНУ уг хэлэлцээрээс гарвал уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд дэлхийн бусад улс орны гаргаж буй хүчин чармайлтад ихээхэн сөргөөр нөлөөлж магадгүй гэж ажиглагчид үзэж байна. АНУ-ын Батлан хамгаалахын сайд Жэймс Мэттис өчигдөр телевизид ярилцлага өгөхдөө дэлхийн дулаарлын асуудалд үл итгэх байр сууринаас ханддагаараа зартай Трамп энэ асуудлаар илүү нээлттэй болж байгааг онцолж байжээ. Ямартай ч, Д.Трамп анхны гадаад улсад хийх айлчлалаа өндөрлүүлж, “Их Долоо”-гийн бүлгийн дээд хэмжээний уулзалтын дараа болдог уламжлалт хэвлэлийн хуралд оролцолгүй нутаг буцсан юм. Тиймдээ ч, тэрбээр ямар шийдвэр гаргах нь олны анхаарлыг ихээр татаж байна.

уриалсан юм. Хэрвээ АНУ уг хэлэлцээрээс гарвал уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд дэлхийн бусад улс орны гаргаж буй хүчин чармайлтад ихээхэн сөргөөр нөлөөлж магадгүй гэж ажиглагчид үзэж байна. АНУ-ын Батлан хамгаалахын сайд Жэймс Мэттис өчигдөр телевизид ярилцлага өгөхдөө дэлхийн дулаарлын асуудалд үл итгэх байр сууринаас ханддагаараа зартай Трамп энэ асуудлаар илүү нээлттэй болж байгааг онцолж байжээ. Ямартай ч, Д.Трамп анхны гадаад улсад хийх айлчлалаа өндөрлүүлж, “Их Долоо”-гийн бүлгийн дээд хэмжээний уулзалтын дараа болдог уламжлалт хэвлэлийн хуралд оролцолгүй нутаг буцсан юм. Тиймдээ ч, тэрбээр ямар шийдвэр гаргах нь олны анхаарлыг ихээр татаж байна.

Энэтхэгт зика вирусийн халдвар тархжээ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага Энэтхэгт зика вирусийн анхны тохиолдол бүртгэгдсэн тухай мэдээлжээ. Энэ талаархи мэдээллийг Энэтхэгийн Эрүүл мэндийн яам ч батласан байна. Зика вирус нь шумуулаар дамжин халдварладаг халдварт өвчин бөгөөд жирэмсэн эмэгтэйчүүд энэ вирусийн халдвар авсан тохиолдолд хүүхэд нь хэт жижиг толгойтой төрөх эрсдэлтэй байдаг. Тус вирус анх 2015 онд

дэгдэж, дэлхийн 10 гаруй оронд тархжээ. Гэхдээ халдварлал нь буурсан учир ДЭМБ олон улсад эрсдэлгүй гэх шалтгаанаар өнгөрсөн оны арваннэгдүгээр сард зарласан онц байдалаа цуцалсан удаатай. Тэгвэл ДЭМБ-ын вэб сайтад хүн амынхаа тоогоор дэлхийд тэргүүлэгч Энэтхэг улсын Гужарат гэх мужид зика вирусийн анхны тохиолдол бүртгэгдсэн тухай мэдээлжээ. Мужийн эмнэлэг жил гаруй хугацаанд

шинжилгээ оношлогоо хийсний дүнд уг тохиолдлыг илрүүлсэн байна. Халдвар авсан хүмүүсийн дунд нэг жирэмсэн эмэгтэй байгаа аж. ДЭМБ одоогоор вирусийн тархалт өргөн хүрээг хамраагүй хэмээн үзэж байгаа ч, оношлогоонд ороогүй халдвартай тохиолдол байж болзошгүйг үгүйсгэхгүй гэдгээ мэдэгджээ. Тиймээс цаашдаа уг вирусийн тархалтад анхаарал хандуулах шаардлагатайг эрх баригчдад нь уриалсан байна.

Манчестерт халдлага үйлдсэн этгээдийн зургийг нийтэд дэлгэлээ

Их Британийн цагдаагийн албанаас Манчестер хотын концертын танхимд террорист халдлага үйлдсэн амиа золиослогч этгээдийн зургийг олон нийтэд дэлгэн харуулжээ. Энэ сарын 22-ны шөнө болсон тэрхүү халдлагын үеэр гэмт этгээд Салман Абедигийн дүрс хяналтын камерт дүрслэгдсэн байна. Тэд гэмт хэрэгтний 22-ны өдрийг хүртэлх үйл ажиллагааг мөрдөн шалгахын тулд ийнхүү зургийг нь нийтэлж, үнэн бодит мэдээлэл өгөхийг иргэдээ хүсчээ. Одоогоор тус халдлагатай холбогдуулан 11 хүнийг баривчлаад байна.

Хамгийн сүүлд гэхэд цагдаагийнхан Манчестерийн хойд хэсэгт самналт хийж, сэжигтний гэрт нэгжлэг явуулж, 20 болон 22 настай хоёр этгээдийг баривчилжээ. Хэргийг эргэн сануулбал, Манчестерийн “Манчестер Арена” концертын танхимд АНУ-ын дуучин Ариан Грандегийн аялан тоглолт болж байх үеэр хэт даврагч бүлэглэлийн хамсаатан этгээд амиа золиослон бөмбөг дэлбэлсний улмаас 22 хүн нас барж, 116 хүн гэмтэж бэртсэн байдаг. Үүний дараа тус улс терроризмын эсрэг онц байдал зарлаж, террорист халдлагатай холбогдуулан нийт 11 хүнийг баривчлаад байна. Хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд Ливийн цагдаагийнхан ч гэсэн оролцож буй аж. Тодруулбал, тус улсын цагдаагийн алба хаагчид гэмт хэрэгтэн Салман Абедигийн эцэг болон ахыг нь баривчилжээ. Террорист халдлагыг хэт даврагч “Лалын улс” бүлэглэл үйлдсэн гэдгээ хүлээн мэдэгдэл хийсэн удаатай.



“British Airways”-ын нислэг зогслоо

Их Британийн авиа компани “Бритиш Эйрвэйс”-ын мэдээллийн технологийн системд томоохон хэмжээний доголдол үүссэний улмаас Лондоны Хитроу, Гатвик чиглэлийн бүх нислэг цуцлагджээ. Орон нутагт энэ сарын 29 амралтын өдөр аж. Тиймээс энэ долоо хоног гурван амралтын өдөр таарч байгаа учир гэр рүүгээ харих гэсэн зорчигчдын дараалал үүссэн байна. Гэвч мэдээллийн технологийн системд нь ийнхүү алдаа гарснаар нислэг зогсч, түр хугацаанд эмх замбараагүй байдал үүсчээ. Энэ талаар “Бритиш Эйрвэйс” компани өнгөрсөн бямба гарагийн орой мэдэгдэл хийсэн байна. Тэд “Мэдээллийн технологийн системд томоохон хэмжээний доголдол үүссэн учраас агаарын тээврийн салбарт сөрөг нөлөө үзүүлж байна” хэмээн мэдэгдсэн байна. Компани эхэндээ Хитроу, Гатвик чиглэлийн нислэг оройн 18:00 цаг хүртэл цуцлагдсан гэж мэдэгдэж байжээ. Гэвч, дараа нь залруулга хийн бүрэн цуцлагдсаныг анхааруулсан байна. Мөн IT-ын гэмтэлд гадны хакерууд нөлөөлсөн гэх нотлох баримт байхгүй аж. Түүнчлэн, Италийн Ром болон Милан, Чехийн Прага, Шведийн Стокгольм зэрэг хотууд руу хийх нислэг нь хойшлогдож болзошгүй байдал үүсчээ.

Гудамжинд шүлэг уншиж байсан хүүг Оросын цагдаа нар хүчээр баривчилжээ

ОХУ-ын нийслэл Москва хотын гудамжинд яруу найраг уянгалуулан уншиж байсан 10 настай хүүг цагдаа нар хүчээр баривчилж буй бичлэг цацагдаж, иргэдийн эсэргүүцэлтэй тулгарчээ. Гар утсаар хийсэн бичлэгт “авраарай” гэж хашхирах хүүг хүчээр чирэн баривчилж буй байдал дүрслэгдсэн байна. Хүүг Оскар Миронов гэдэг аж. Цагдаагийнхан түүнийг баривчилсан шалтгаанаа гудамжинд гуулга гуйж байсан гэж тайлбарласан бол хүүгийн эцэг нь “Театрт жүжигт тоглохын тулд шүлгээ чанга дуугаар уншин сургуулиг л хийж байсан шүү дээ” гэж ярьсан байна. Хүүг цагдаагийн газарт дөрвөн цаг саатуулсны эцэст суллажээ. Ингэхдээ эцгийг нь 500 рублиэр торгосон байна. Хэргийг эдүгээ шалгаж буй бөгөөд үр дүн нь эцэслэн гараагүй байгаа аж. Оросын цагдаа нар Москвад гуравдугаар сард зохион байгуулагдсан сөрөг хүчний лидер Алексей Навалнийгийн удирдсан Засгийн газрын эсрэг жагсаалын үеэр олон тооны залуусыг хүч хэрэглэн баривчилж байсан юм.



MMINFO. Тал нутгийн цахим мэдээлэл

ЦАГ ҮЕ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

“БОЛОВСРОЛ-2017” НЭЭЛТТЭЙ ХААЛГААР ЗОЧЛОХОД..



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт**

Зах зээлийн үеийн дээд боловсролын тогтолцоо нь иргэдийн боловсролын хэрэгцээг хангахад чиглэсэн байдаг нь олон улсын жишиг. Гэхдээ аль нэг салбарт боловсон хүчин илүүдэлтэй байна гээд тухайн чиглэлийн сургуулийг хаах юм уу элсэлт авахгүй байхыг тулган шаардах эрх бидэнд үгүй. Байгаль орчин, усны болон уул уурхайн нөхөн сэргээлийн мэргэжилтэн, хүүхдийн хөгжил, сургалтын технологийн чиглэлийн мэргэжлийн боловсон хүчин нэн шаардлагатай байгаа юм. Мөн сургуулийн өмнөх боловсрол, сурган хүмүүжүүлэх чиглэлээр болон соёлын өвийг сэргээх, сонгодог урлаг, био анагаах, сувилалын мэргэжилтэн, уул уурхайн маркшейдер, геологи, эрдсийн ашиглалт, боловсруулалтын чиглэлийн инженерүүд ч эрэлттэй хэвээр байгаа. Энэ талын мэдээллийг өнөөдрийн нээлттэй хаалганы өдөрлөг болоод боловсролын чиглэлээр зохион байгуулж буй үзэсгэлэн яармаг, хэвлэл мэдээллээс ч авах боломжтой”-г төгсөгчиддөө хандаж зөвлөв.

Харин тус өдөрлөгийг зорин ирж, 60-аад асраар уйгагүй зочлон яваа зарим иргэний хувьд хүүхдээ сургах хүслийг нь сургалтын төлбөр хэмээх “шүдний өвчин” чөдөрлөж байхад нөгөө нэг нь “Сургуулиуд орлогообододямарч хяналтгүй элсэлт авч байна. Хөөрхий, эцэг эх нь болохоосоо болохгүйгээ хүртэл зүтгэж дөрвөн жил сургалтын төлбөрийг нь төлдөг. Эцэст нь дээд сургууль төгссөн дипломтой ажилгүйчүүдийн тоо л өснө шүү дээ. Сургуулиуд хүүхэд элсүүлж сургалтын төлбөрөө л авч байвал цаана нь тухайн хүүхдийн ирээдүй, айл гэрийн амьдрал ахуйд эдийн засгийн хохиролтой байх нь хамаагүй болжээ” хэмээн санаа зовонгуй байдлаа нууж эс чадан эсэргүүт үг унагана.

ХААИС-ийн сургалт эрхэлсэн дэд захирал Б.Буянзаяа “Хуучин БСШУЯ-аас хяналтын тоог тогтоож өгдөг байсан. Одоо тухайн сургуулиудын удирдах зөвлөл хяналтын тоог тогтоодог. Гэхдээ хөдөлмөрийн зах зээл, нийгмийн эрэлт хэрэгцээг харж байж хяналтын тоог тогтооно. Манай сургуулийн хувьд сургалтын орчин, хэчнээн оюутан хамруулах боломжтой вэ гэдгээ

...“Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа” гэдэг учраас энэ алхмыг амжилттай хийхэд сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулиуд чухал үүрэг гүйцэтгэнэ. Харин тэд ямар бодлогоор юу хийж, яаж ажиллаж байна вэ гэдэг асуултад энэхүү нээлттэй хаалганы өдрөөр хариулт өгөхийг хичээсэн юм...


харж хяналтын тоог тогтоодог юм. Хяналтын тоо, сургалтын төлбөр хоёр хоорондоо уялдаж ёстой. Сургалтын төлбөр сургуулиудын орлогын эхүүсвэр учраас заримдаа хяналтын тоог нэмэх тохиолдол бий” гэв.

“Боловсрол-2017” нээлттэй хаалганы өдөрлөгийн эхний өдөр нэг иймэрхүү. Эцэг, эхчүүд хонхны баярын дараа улсын шалгалт, элсэлтийн оноо, хяналтын тоо, сургалтын төлбөр гэдэг даваануудыг давж байж хүүхдээ мэргэжил боловсролтой болгох нь. Харин хоёр дахь өдөр нь буюу өнгөрсөн бямба гарагт сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын

салбарынхан өргөн түмэндээ өндөр “үүдээ дэлгэсэн” юм. “Өндөр” гэж тодотгосоны учир нь манай улсын нийт иргэд бичиг үсэг тайлагдалт, сургуульд сурсан байдал буюу боловсролын дипломоороо дэлхийд чамлахааргүй байр эзэлдэг. Гэвч Монгол Улсын хөгжил, өрсөлдөх чадвараараа бид хаана яваа билээ. Нийгэм, эдийн засгийн салбарт хоёр нийгмийн шилжилт хурдацтай явагдсан ч, боловсролын салбарт энэ нь хожуу эхэлсэн. Тиймээс зах зээлийн нийгэмд шилжээд багагүй хугацаа өнгөрсөн ч саяхнаас л ерөнхий боловсролын сургуулиа 10 жил

байсныг 12 жил болгож, үүнийг дагаад сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд буюу цэцэрлэгийн сургалт, хүмүүжлийн хөтөлбөр ч өөрчлөгдсөн юм. Энэхүү өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцыг бид үр хүүхдүүдтэйгээ хамт туулж байгаа. Улс орноо хөгжүүлж гэвэл иргэнээ хөгжүүлж, иргэнээ хөгжүүлж гэвэл үр хүүхдээ багаас нь зөв хүмүүжүүлж, суурь боловсролыг нь зөв тавих хэрэгтэй. “Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа” гэдэг учраас энэ алхмыг амжилттай хийхэд сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулиуд чухал үүрэг гүйцэтгэнэ. Харин тэд ямар бодлогоор юу хийж, яаж ажиллаж байна вэ гэдэг асуултад энэхүү нээлттэй хаалганы өдрөөр хариулт өгөхийг хичээсэн юм. Тодруулбал, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, ерөнхий боловсролын үйлчилгээ, сургалтын хөтөлбөр хэрэгжилтийн хүртээмж, чанар, хүрсэн төвшинг танилцуулан боловсролын бодлого хэрэгжилтийн онцлог, ололт амжилт, сайн туршлагыг хэрхэн түгээн дэлгэрүүлж буйгаа

танилцуулж байлаа. Уг арга хэмжээнд нийслэлийн төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн харьяа ахлах сургууль, тусгай болон спортын, лаборатори сургуулиуд, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын зээлийн сан, Насан туршийн боловсролын төв, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, нийслэл, дүүргийн Боловсролын газар, хэлтсүүд, зарим олон улс болоод иргэний нийгмийн байгууллагууд оролцсон юм. Тэд үзүүлэн, үзэсгэлэн гаргаж, нээлттэй хичээл, уралдаан тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулав. Мөн хүүхдийн хөгжлийн сорил авч, боловсролын зарим баримт бичгийг нөхөн олгож, боловсролын зээл өгч, элсэлтийн ерөнхий шалгалтын тест бөглөх, сургалтын тоног төхөөрөмж дээр ажиллах аргыг танилцуулан туршилт хийлгэж, хүүхдийн хоолны амтлаганы үйлчилгээ үзүүлсэн нь ирсэн зочдын сэтгэлд нийцэж байлаа. Хүмүүсийн сонирхолыг хамгийн их татаж буй нь урлаг, спорт, техник технологийн үзүүлэх тоглолтууд байсан юм.



NO STRESS

ОНЦЛОХ ГЭРЭЛ ЗУРАГ



Цагдаа нар дүүжинээр эрүүлэг тариа

Гэрэл зурагч Г.АРГУУЖИН

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 27
Шөнө 9

Нөгөөдөр
Өдөр 26
Шөнө 12

Өдрийн зурхай

ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Наран ургах, шингэх: 05.10-20.37
Үс засуулбал: Бие эрхтний, хүч сайжирна



Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, талхи татах, сэтгэл луутантай ноёрхлоо зэргийг цээрлэх хэрэгтэй ба угаал үйлдэх, бороо хур оруулах, ээтгэрийг ноёлхотгох, хөгжлийн зэлсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, голог тэжээхэд түү. Өдрийн сайн цаг нь баф, луу, тогой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн урагш төрөө гаргавал зохистой. Модон хохитой өдөр. Үс шинээр үргээлэх буюу засуулбал бие эрхтний, хүч сайжирна.

FOOTBALL NEWS

“Барселона” Эзэн хааны цомг түрүүлээ



Испанийн Эзэн хааны цомын тэмцээний финалын тоглолт өнгөрсөн бямба гарагийн шөнө боллоо. Аваргийн төлөө Каталони алдарт “Барселона” клуб “Алавес”-тэй тулж, 3:1-ээр буулгаж авлаа. Ингэснээр энэ улирлыг ямар ч байсан цомтой үдэж байгаа юм. Тоглолтын 30 дахь минутад Месси тооны харьцааг нээсэн ч “Алавес”-аас Тео тэнцүүлсэн. Гэвч 45 дахь минутад Неймар тооны харьцааг холдуулж, эхний үеийн шүүгчийн мэдлийн цагт Пако Алькасер хожлын гоол оруулжээ.

“Арсенал” Холбооны цомг түрүүлээ

Английн холбөмбөгийн холбооны цом буюу “FA Cup”-ын финалын тоглолт өнгөрсөн бямба гарагийн шөнө боллоо. Финалд Лондон хотын хоёр баг болох “Арсенал” болон “Челси” клубүүд учраа таарсан билээ. Тэгвэл энэ тоглолтод “Их буучид” өрсөлдөгчөө 2:1-ээр буулгаж авснаар улирлыг цомтой өндөрлүүлээ. Тоглолтын 4 дэх минутад

Алексиси Санчес гоолдож, тооны харьцааг нээсэн. Харин 68 дахь минутад Виктор Мозес торгуулийн талбайд жүжиглэн унасан улмаас хоёр дахь шар хуудсаа авч, талбайг чөлөөлсөн. Гэвч хүн дутуу “Челси” бууж өгөлгүй 76 дахь минутад Коста тэнцүүлсэн. Харин 79 дэх минутад Рамсей гоолдоноор “Арсенал” энэ улирлыг цомтой өндөрлүүлээ.

КИНО ЕРТӨНЦ

“Хуримын даашинзтай бүсгүй” КИНО НЭЭЛТЭЭ ХИЙНЭ

“Big Line Film”, “Oranger Entertainment”, “Red Point”-ийн хамтын бүтээл “Хуримын даашинзтай бүсгүй” киноны нээлт энэ сарын 30-нд болно. Тус киноны зохиолч, найруулагчаар З.Батболд ажилласан гэнэ. Тэрбээр үзэгч та бүхний сайн мэдэх “Боолын гэрээ”, “Бурхан өршөөг”, “Аз жаргал & bad boy”, “Сайн уу амьдрал минь” зэрэг киног найруулсан билээ. Харин гол дүрүүдэд УДЭТ-ын залуу жүжигчин Б.Шинэбаяр болон Б.Батмаа, У.Билэгт-Од, Б.Батмэнд, Д.Гүрсэд, А.Цэгмэд нар тогложээ.

Тус кинонд амьдралд дөнгөж хөл тавьж буй залуусын хайр дурлал, нөхөрлөл, хүн чанарын тухай өгүүлэх гэнэ. Дашрамд сонирхуулахад, “Хуримын даашинзтай бүсгүй” киноны нээлт “Тэнгис” кино театрт 19:00 цагт болно.



ДУУЛГАХ СОНИН

Л.Чинбат үндэсний бөхийн холбоог удирдана

Монголын үндэсний бөхийн холбооны ээлжит бус “Их Эе” хурал болжээ. Гурван шатны шүүхийн шийдвэрийн дагуу хуралдаж буй энэ хурлаар холбооны тэргүүнийг солих тухай асуудлыг хэлэлцсэн бөгөөд олонхийн саналаар бөхийн холбоог “Гацуурт” компанийн ерөнхий захирал Л.Чинбат тэргүүлэхээр болсон байна. Тэрбээр өмнө нь Монголын Чөлөөт

бөхийн холбооны Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан юм. Холбооны тэргүүний сонгуульд дөрвөн хүн өрсөлдсөн боловч Х.Баянмөнх, А.Сүхбат, н.Хүдэрбаатар нар нэрээ татсанаар Л.Чинбат 100 хувийн саналаар сонгогджээ. Харин Үндэсний бөхийн холбооны тэргүүн асан Р.Нямдорж нь энэ холбоог сүүлийн 15 жил удирдаж байсан билээ.

Хакүхо 38 дахь түрүүгээ авлаа

Японы мэргэжлийн сүмо бөхийн тавдугаар сарын Нацубашё Осака хотноо өндөрлөж, Ёкозүна Хакүхо М. Даваажаргал 38 дахь түрүүгээ авлаа. Мэргэжлийн сүмо бөхийн 69 дэх их аварга сүүлийн өдөр 1036 дахь даваагаа авч мэргэжлийн сүмо бөхийн болон өөрийнхөө хувийн амжилтыг ахиулан түрүүлэв. Хакүхо аварга Нацу башёгийн 14 дэх өдөр нутгийн бөх Оэки Терүнофүжитэй Г.Ган-Эрдэнэтэй барилдсан. Хоёр бөх 13 удаагаа таарч барилдахад аварга ес дэх удаагаа давснаар түрүүлэх болзлоо хангасан юм. Башёгийн сүүлийн өдөр буюу өчигдөр Ёкозүна Харүмафүжиг ёрикири мэхээр давж 15 дахь даваагаа авлаа. Түүний хувьд Нацу башёд найм дахь удаагаа түрүүлж байгаа юм байна.



Бидэнд тохиолдсон

Күндэн хөгтэй явдлууд

Соёл Маа

Саяхан даа ажлаа тараад хальт дэлгүүр ортол багадаа тоглож байсан хөвгүүдтэй таарав. Сүйд болоод л нэг нэгийгээ шинжиж байснаа намайг “Хүн нээрээ ингэж өөрчлөгдөх гэж, тэвэг тоглоод гүйж байсан охин өндөр өсгийг, албан хувцастай... төрөл арилжсан юм шиг. Тэвэгдээд л 5, 10 гэж угсраад л, багшийг хар хүн хар гээд тэвэг өшиглөж байсан охин гэж хүн төсөөлөхгүй дээ” гэсэн. Гутлаа далжийтал тэвэг тоглодог байжээ ккк

УЛАМЖЛААТ АНАГААХ УХААНЫ "ГАНЗҮҮ" ЭМНЭЛЭГ



Манай эмнэлэг дотор 5 цув, 6 сав эрхтэний өвчлөлийг уламжлаат анагаах ухааны таван заслын аргаар эмчилж, 80-аас дээш хувьтай үр дүн үзүүлдэг.

- Бид танд:**
- Ган болон мөнгөн зүү, шахиагаан зүү
 - Хануур, сам соруул
 - Шарлаг
 - Бумба төвөнө засал
 - Халуун чулуу, давсан халуун жин засал
 - Эмчилгээний цэгэн барил
 - Архи, сүү, сүүлэн тостой бүтэн биеийн барил зэрэг уламжлаат анагаах ухааны эмчилгээ үйлчилгээ, мэдрэл, харшил, хүүхэд, эмэгтэйчүүдийн оношлогоо эмчилгээг цогцоор нь хийж үйлчилнэ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ БИД ҮЗҮҮЛНЭ
Холбогдох утас: 9999-5584
9900-2332



Салбар 1 хаяг: Найрсаг Улаанбаатар их дэлгүүрийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Өдрийн эмчилгээ/



Салбар 2 хаяг: III хороолол, 28 дугаар сургуулийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Хэвтүүлэн эмчилнэ/

